



ХЭЛТЭС, АЛБАДЫН ДАРГА НАРТ

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж 16,
Утас: 32-75-75, Факс: (976-11) 31-02-04
E-mail: info@chingeltei.gov.mn

2017. 01. 23 № 3/157
танай _____ -ны № _____ -т

Хуваарь хүргүүлэх тухай

Дүүргийн “Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн”-ий 2017 оны хуваарийг хавсралтаар хүргүүлж байна.

Шуурхай зөвлөгөөнд оролцохдоо Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/768, дүүргийн Засаг даргын 2014 оны А/103 дугаар захирамжаар батлагдсан “Шуурхай зөвлөгөөн зохион байгуулах тухай” журмыг баримтлан хэрэгжүүлэхийг мэдэгдье. Үүнд:

1. Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн болон тулгамдаж буй асуудлын хүрээнд өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг Нийслэлийн “Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн”-ий танилцуулгын хамтаар шуурхай зөвлөгөөн бүрийн дараагийн 7 хоногийн “Лхагва” гарагт багтаан батлагдсан маягтын дагуу гарган дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст /chingeltei_naraaz@yahoo.com/ ирүүлж байх.

2. Шуурхай зөвлөгөөнд оролцогч албан тушаалтан нь зөвлөгөөн дээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг дүүргийн Засаг даргын өмнө биечлэн хариуцах.

3. Шуурхай зөвлөгөөнд оролцогч албан тушаалтан нь зөвлөгөөн дээр өгөгдсөн үүрэг, даалгаврыг өөрийн байгууллагын хамт олонд ажлын 8 цагийн дотор багтаан мэдээлж ажил хариуцан гүйцэтгэх албан тушаалтнуудыг үүрэгжүүлэх.

4. Зөвлөгөөнд ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй, албан томилолттой, хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд өөрийн биеэр оролцоно.

5. Шуурхай зөвлөгөөнд оролцох албан тушаалтан хүндэтгэх шалтгаанаар оролцож чадахгүй тохиолдолд зөвлөгөөн удирдагчаас чөлөө авч, албан ёсны орлогчоо оролцуулан ирцийн бүртгэлд бүртгүүлж байна. Албан ёсны чөлөө аваагүй тохиолдолд орлон ирсэн албан тушаалтныг тухайн шуурхай зөвлөгөөнд оролцуулахгүй.

6. Шуурхай зөвлөгөөнийг хүндэтгэх шалтгаангүйгээр тасалсан, шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийг хугацаанд нь биелүүлээгүй, чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйл, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль, тогтоомж, дүүргийн Засаг даргатай байгуулсан Үр дүнгийн гэрээг үндэслэн төрийн албан тушаалтанд түүнийг томилсон төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр сахилгын шийтгэл ногдуулна.

Мөн аливаа зарласан хурал, зөвлөгөөн, олон нийтийн арга хэмжээнд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хоцорч, таслахгүй байх ба бүх нийтээр тэмдэглэх баяр ёслол болон амралтын өдрүүдэд гар утсаа нээлттэй байлган шаардлагатай тохиолдолд үүрэг гүйцэтгэхэд бэлэн байхыг анхааруулж байна.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА



А.ДАМЦАГДОРЖ

D:\2017 onii aji\alban bichig\A4.docx

1150200656

БАТЛАВ

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ

ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ

ДҮҮРГИЙН УДИРДАХ АЖИЛТНЫ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНИЙ

2017 ОНЫ ХУВААРЬ

2017 он

№	САР	ӨДӨР	ХУГАЦАА	ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ГАЗАР
1	1	24	11.00	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд болно.
2				
3	2	8		
4		21		
5	3	07		
6		21		
7	4	4		
8		18		
9	5	9		
10		23		
11	6	6		
12		20		
13	7	4		
14		18		
15	8	8		
16		22		
17	9	5		
18		19		
19	10	3		
20		17		
21	11	7		
22		21		
23	12	5		
24		16		